



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Чойбалсан сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2026/009/НА-СТА-ТТЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Чойбалсан хот <b>2026 он</b></p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитор: Ч.Удвалноров Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Аудитын илрүүлэлт .....	8
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	9

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг  
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000  
Утас: 7058-4203

2026.03.25 № 404  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН  
ЧОЙБАЛСАН СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Г.ТӨРБОЛД ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Чойбалсан сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 81.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дорнод аймгийн Чойбалсан сумын ИТХ-ын 2025 оны 37 дугаар тогтоолоор “Хулстай хөгжил” ОНӨҮГ нь татан буулгасан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

2126050224

#### **Бусад асуудлын хэсэг**

Чойбалсан сумын 2025 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,616,753.8</b>	<b>1,776,670.7</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	974,092.7	1,146,768.3
33	АВЛАГА	124,817.5	68,956.2
35	БАРАА МАТЕРИАЛ	517,843.7	442,290.2
36	НӨӨЦИЙН БАРАА	-	118,656.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,575,068.6</b>	<b>5,580,998.3</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,575,068.6	5,580,998.3
39200	Биет хөрөнгө	2,504,345.4	3,514,159.1
39300	Биет бус хөрөнгө	2,070,723.2	2,066,839.2
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>6,191,822.4</b>	<b>7,357,669.0</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>19,389.7</b>	<b>310,987.5</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,389.7	310,987.5
41300	Өглөг	19,389.7	310,987.5
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,172,432.8</b>	<b>7,046,681.4</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,172,432.8	7,046,681.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,489,431.5	2,489,431.5
51200	Хуримтлагдсан үр дүн	3,568,565.5	4,442,814.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	114,435.8	114,435.8
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>6,191,822.4</b>	<b>7,357,669.0</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>3,199,303.96</b>	<b>4,267,936.42</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	779,886.37	903,651.76
110	Орлогын албан татвар	430,112.84	426,323.14
1100	Хувь хүний орлогын албан татвар	463,258.05	461,323.14
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(33,145.21)	(35,000.00)
113	Хөрөнгийн албан татвар	49,821.85	153,062.05
118	Бусад татвар, төлбөр, хураамж	299,951.68	324,266.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	616,597.85	3,364,284.66
120	Нийтлэг татварын бус орлого	586,652.85	1,410,745.52
122	Тусламжийн орлого	29,945.00	831,447.62
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	1,122,091.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,802,819.73	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,549,305.81</b>	<b>1,620,861.88</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,549,305.81	1,620,861.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,494,511.37	1,588,727.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	760,325.02	889,881.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,480.47	110,820.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,702.35	142,588.50
2104	Хангамж, бараа материалын зардал	76,374.39	107,588.25
2105	Нормативт зардал	11,751.94	4,010.76
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,783.50	18,208.10
2107	Томилолт, зочны зардал	27,460.00	10,934.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,994.94	13,201.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	391,638.75	291,493.70

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,794.45	32,133.97
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,649,998.14</b>	<b>2,647,074.54</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>614,580.48</b>	<b>1,769,208.34</b>
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>(614,580.48)</b>	<b>(1,769,208.34)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>1,035,417.67</b>	<b>877,866.20</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,132,836.3	5,132,836.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,178.8	4,178.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,137,015.1	5,137,015.1
4	Тайлант үеийн үр дүн	1,035,417.7	1,035,417.7
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,172,432.8	6,172,432.8
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,172,432.8	6,172,432.8
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,617.5)	(3,617.5)
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,168,815.3	6,168,815.3
9	Тайлант үеийн үр дүн	877,866.2	877,866.2
10	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,046,681.4	7,046,681.4

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,687,222.96</b>	<b>2,950,275.33</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>779,886.37</b>	<b>903,651.76</b>
110	Орлогын албан татвар	430,112.84	426,323.14
1100	Хувь хүний орлогын албан татвар	463,258.05	461,323.14
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(33,145.21)	(35,000.00)
113	Хөрөнгийн албан татвар	49,821.85	153,062.05
118	Бусад татвар, төлбөр, хураамж	299,951.68	324,266.56
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,288.64	962.56
1181	Газрын төлбөр	298,663.04	323,304.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>104,516.86</b>	<b>2,046,623.57</b>
120	Нийтлэг татварын бус орлого	89,516.86	93,084.43
122	Тусламжийн орлого	15,000.00	831,447.62
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	1,122,091.52
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,802,819.73</b>	<b>-</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,236,243.96</b>	<b>1,371,710.48</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,236,243.96</b>	<b>1,371,710.48</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,181,449.52	1,339,576.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	755,067.46	895,138.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,480.47	110,626.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	124,363.22	144,108.88
2104	Хангамж, бараа материалын зардал	26,557.81	18,009.81
2105	Нормативт зардал	1,274.40	347.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,394.33	25,049.03
2107	Томилолт, зочны зардал	27,460.00	10,934.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,354.69	1,935.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	132,497.14	133,425.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,794.4	32,133.97

III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,450,979.00</b>	<b>1,578,564.86</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>639,253.66</b>	<b>1,405,889.23</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>639,253.66</b>	<b>1,405,889.23</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	639,253.66	1,405,889.23
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(639,253.66)</b>	<b>(1,405,889.23)</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>811,725.34</b>	<b>172,675.63</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	162,367.34	974,092.69
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	974,092.69	1,146,768.32

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,292,873.0</b>	<b>2,674,774.9</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,268,873.0</b>	<b>2,419,145.8</b>
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>-</b>	<b>55,629.1</b>
<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС</b>	<b>24,000.0</b>	<b>200,000.0</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,174,863.10</b>	<b>2,674,774.90</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>(748,729.80)</b>	<b>1,263,885.70</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,336,046.10</b>	<b>1,231,751.70</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	921,518.70	895,139.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,191.90	110,626.50
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164,637.70	144,108.90
Хангамж, бараа материалын зардал	29,277.00	17,889.80
Нормативт зардал	1,000.00	347.2
Эд хогшил, урсгал засварын зардал	25,700.00	25,049.00
Томиллолт, зочны зардал	29,000.00	10,934.60
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,610.00	1,935.60
Бараа үйлчилгээний бусад зардал	47,110.80	25,721.10
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>(2,084,775.90)</b>	<b>32,134.00</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,803,592.90</b>	<b>1,410,889.20</b>
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>120,000.00</b>	<b>-</b>
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>1,243,582.80</b>	<b>172,675.63</b>
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(1,243,582.80)</b>	<b>(172,675.63)</b>
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,243,582.80)	(172,675.63)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	974,092.70
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,146,768.30

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>107,824.8</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>107,824.8</b>
122	Тусламжийн орлого	107,824.8
1221	Хандив тусламж /дотоод/	107,824.8
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	107,824.8
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,415.0
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,409.8
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>107,824.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>107,824.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>107,824.8</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	120.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	107,704.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,289.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	98,415.0

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 24.3 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 2 зөвлөмж хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлөөс 57.5 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

**3.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой**

**Илрүүлэлт:** Тайлант оны сумын төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн ч түгээмэл тархацтай АМНАТ-ын төлөвлөгөө 15.0 сая төгрөг буюу 100 хувиар, хадгаламжийн хүүний татварын төлөвлөгөө 6.5 сая төгрөг буюу 9.1 хувиар, галт зэвсгийн албан татварын төлөвлөгөө 0.5 сая төгрөг буюу 18.4 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 0.5 сая төгрөг буюу 35.8 хувиар, хүү торгуулийн орлого 1.7 сая төгрөг буюу 31.1 хувиар тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлэх.

**2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой**

**Илрүүлэлт:** Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих 179 мэдээллээс 4 мэдээллийн хугацааг хоцроосон байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулахтай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны цахим хуудаст оруулах мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант оны сумын төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн ч түгээмэл тархацтай АМНАТ-ын төлөвлөгөө 15.0 сая төгрөг буюу 100 хувиар, хадгаламжийн хүүний татварын төлөвлөгөө 6.5 сая төгрөг буюу 9.1 хувиар, галт зэвсгийн албан татварын төлөвлөгөө 0.5 сая төгрөг буюу 18.4 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 0.5 сая төгрөг буюу 35.8 хувиар, хүү торгуулийн орлого 1.7 сая төгрөг буюу 31.1 хувиар тус тус тасарсан байна.	1	24.3					1	24.3				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>24.3</b>					<b>1</b>	<b>24.3</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих 179 мэдээллээс 4 мэдээллийн хугацааг хоцроосон.	1	-	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>